



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/150

Алтанбулаг

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг
сунгасантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5, "в", 29.1.6 "а", "ж", "л", 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.9, 10.4.14, 10.7.32, дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйл, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 70 дугаар зүйлийн 70.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1.1, сумын Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг 2021 оны 08 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд сунгасантай холбогдуулан Коронавируст (Ковид-19)-ын халдварт цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу сумын Шуурхай штаб, сумын Эрүүл мэндийн төвийн ажлын хариуцлагыг өндөржүүлж ажилласугай.

2. Үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний байгууллага, амралтын газар, хоол үйлдвэрлэлийн газруудын үйл ажиллагаанд хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, ариутгал халдваргүйжүүлэлт хийж иргэдэд үйлчлэх талаар мэдээлэл, таниулга хийж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Б.Одмаа)-д даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд хүүхдийг гадаа олон цагаар тоглуулахгүй, олон нийтийн газраар явуулахгүй байхад эцэг эх, асран хамгаалагч нар онцгой анхаарч, иргэн бүр дор бүрнээ хариуцлагатай байж, өөр хот, аймаг яваад ирсэн тохиолдолд гэрийн тусгаарлалтын дэглэмийг мөрдөн иргэний үүргээ биелүүлэхийг нийт иргэдэд уриалж ажиллах, ажил зохион байгуулахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга (Б.Баттулга), 3 дугаар багийн Засаг дарга (Г.Жамбалдорж) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Янжиндулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ